2021 оны 02 сарын 09-ний өдөр Дугаар А/74 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” 318 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан мэдээллийн технологийн шийдлийг ашиглан гамшгаас хамгаалах хариу арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т даалгасугай.

2.Дээрх хариу арга хэмжээний хүрээнд зохион байгуулах ажилд шаардагдах хавсралтад баталсан 201,500,000 /хоёр зуун нэг сая таван зуун мянга/ төгрөгийг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Т.Оюунчимэг/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Ихбаяр/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 09-ний өдрийн
А/74 дүгээр захирамжийн хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРТ /КОВИД-19/ ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Байгууллага	Мөнгөн дүн
1	Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн smartcar системээр дамжуулан хөл хорионы үед замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэлд тусгай зөвшөөрөл олгох модульд нэмэлт хөгжүүлэлт хийх	9,500,000
2	“Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоогоор зорчих иргэдийн цахим бүртгэл, хяналтын систем хөгжүүлж, qr.ulaanbaatar.mn системд бусад нэмэлт хөгжүүлэлт хийх	9,500,000
3	Нийслэлийн хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэлийн систем, дашборд, тайлангийн модуль хөгжүүлж, дундын мэдээллийн санд api сервисээр холбох	18,900,000
4	Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 7 товчоодод хяналтын камерууд шинээр суурилуулах	163,600,000
Нийт дүн		201,500,000